СЭКЕРРЕСОРСУС МОНГОЛИА

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ХОТГОРЫН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан:

БОУАӨЯ-БОҮАХэлтсийн
Байгаль орчны стратегийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн — Б.Солонго

Боловсруулсан: “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ний

Байгаль орчны ахлах мэргэжилтэн — Б.Мядагбадам

Байгаль орчны мэргэжилтэн — Ч.Төрбат

2025 он

АГУУЛГА

1.	Төслийн үе шатны хэрэгжилтийн талаарх товч танилцуулга	3-14
2.	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	15-17
3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18-73
4.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	74-77
5.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	78-81
6.	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	82-83
7.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	84-85
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	87-92
9.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	93-106
10.	Орчны хяналт шинжилгээний биелэлт	107-121
11.	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний биелэлтийн тайлан	122-124
12.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	125-127
13.	Дүгнэлт	128-129
14.	Хавсралтууд	130

УДИРТГАЛ

Сэкер Ресорсус Монголиа ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдаж уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-012728, MV 017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүд бүхий Хотгорын чулуун нүүрсний ордыг эзэмшиж байна.

Хотгорын чулуун нүүрсний ордод 2007-2010 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2-011 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны XXI-17-01 тоот дүгнэлтийг үндэслэн АМГ-ын даргын 2012 оны 02 сарын 16-ны өдрийн 94 тоот тушаалаар нийт боломжтой болон бодитой (B+C) зэрэглэлээр 160.1 сая.тн, үүнээс бодитой (B) зэрэглэлээр 118.3 сая.тн, боломжтой (C) зэрэглэлээр 41.8 сая.тн чулуун нүүрсний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд хүлээн авсан байна. Мөн Хотгор чулуун нүүрсний ордын зүүн хэсэгт 2006-2017 онуудад гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны XX-13-07 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн н/ 112 тоот тушаалаар нийт боломжтой болон бодит (B+C) зэрэглэлээр 171.04 сая.тн, үүнээс бодитой зэрэглэлээр 124.58 сая.тн, боломжтой (C) зэрэглэлээр 46.46 сая.тн чулуун нүүрсний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Улмаар геологи, уул уурхайн зөвлөх үйлчилгээ, зураг төслийн Гложекс Консалтинг ХХК нь 2022 онд Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ тодотгол 1-г боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам ашигт малтмал, газрын тосны газрын ЭБМЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Т/22-11-02 тоот дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 02 сарын 14-ны өдрийн Т/18 тоот тушаалаар батлуулсан.

Хотгорын чулуун нүүрсний уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу бүтэн жилийн хугацаанд буюу 347 хоногт ажилласан бол 10,001,60 тн нүүрс олборлолт хийж, 54,312,000м^3 хөрс хуулалт хийгдэх байсан боловч Шинэжинст сумын багуудийн иргэдийн нийтийн хурал хүлээгдсэн шалтгааны улмаас уурхайн БОННҮ-ний тодотголын тайлан 2025 оны 08-р сарын 27-ны өдөр батлагдсан тул энэхүү БОМТ батлагдсаны дараа буюу 2025 оны 10 сарын 10-ны өдрөөс уурхайн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2 сарын хугацаанд 12,765,200 м^3 хөрс хуулалт хийж 2,224,200 тн нүүрс олборлох төлөвлөгөөтэй болсон.

Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 5 жилийн хугацаанд 1,120,135,000 төгрөг, эхний жилийн зардал 195.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-н дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

БҮЛЭГ 1.

ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	Хотгорын нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч:	Сэкер ресорсус монголиа ХХК
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	9011305106
Регистрийн дугаар:	2862468
Хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил махатма ганди, Корпорэйт зочид буудал энд конвеншн центр, 6-р давхар
Төслийн байршил:	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт хэрэгжинэ
Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дугаар:	- MV-012728 - MV-017057 - MV-017060 - MV-017061 - MV-017062 - MV-021487 - MV-021488

Төслийн байгаль орчны холбогдох албан тушаалтны мэдээлэл:

№	Нэр	Албан тушаал
1	Э.Батцэрэн	Сэкер ресорсус монголиа ХХК-ний ХАБЭАБО хэлтсийн дарга
2	Ч.Төрбат	Сэкер ресорсус монголиа ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн
3	Б.Мядагбадам	Сэкер ресорсус монголиа ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн
4	Ч.Бямба-Бат	Эрхэт Түнш ХХК-ний ХАБЭАБО менежер
5	Б.Батцэрэн	Эрхэт Түнш ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн
6	Б.Энх Ирээдүй	Эрхэт Түнш ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн
7	Б.Отгонсүрэн	Өрнөх Үндэс ХХК-ний ХАБЭАБО мэргэжилтэн

Төсөл товч мэдээлэл:

Сэкер Ресорсус Монголиа ХХК нь анх 2006 онд Гобикоул Энд Энержи нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2022 онд нэрээ өөрчлөн, Сингапур улсын хөрөнгө оруулалттайгаар “Сэкер Ресорсус Монголиа” ХХК болсон. Хотгорын нүүрсний орд нь зэргэлдээ болон үргэлжилсэн 7 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг (MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488) хамран байрладаг. Анх 11340Х хайгуулын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ны даргын 897 тоот шийдвэрээр 2006 оны 02 сарын 13 өдөр Гоби Коул энд Энержи ХХК-д олгосон бөгөөд 7459Х, 7458Х, 12728А, 13782Х тусгай зөвшөөрлийн талбайнуудыг авч өөрийн хөрөнгөөр геологи

хайгуулын ажлыг хийж гүйцэтгэж, улмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон байна.

Төслийн байршил:

Засаг захиргааны хувьд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км, Шивээхүрэн боомтоос баруун хойш 320 км-т зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд далайн түвшинээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана.



Зураг 1. Төслийн байршил

1.2 Төслийн зорилго

Хотгорийн чулуун нүүрсний ордод Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээх зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

1.3 Төслийн хүчин чадал

Ил уурхайн хүчин чадал - Ил уурхайн хүчин чадал нь нүүрс баяжуулах үйлдвэрийг анхдагч нүүрсээр тасралтгүй тэжээх, уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цулын хэмжээг жигд байлгах, ил уурхайн хүрээ хязгаарт өртсөн нөөцийг бүрэн ашиглах гэсэн үндсэн нөхцөлүүдээс бүрдэнэ.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал

№	Хүчин чадал	Хэмжих нэгж	Утга
1	Бутлуурын хоногийн хүчин чадал	мян.тн	12.98
2	Үйлдвэрийн хоногийн хүчин чадал	мян.тн	8.77
3	Үйлдвэрийн жилийн хүчин чадал	мян.тн	8,000

1.4 Төслийн дэд бүтэц

Усан хангамж:

Ил уурхайн хүчин чадал - Ил уурхайн хүчин чадал нь нүүрс баяжуулах үйлдвэрийг анхдагч нүүрсээр тасралтгүй тэжээх, уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цулын хэмжээг жигд байлгах, ил уурхайн хүрээ хязгаарт өртсөн нөөцийг бүрэн ашиглах гэсэн үндсэн нөхцөлүүдээс бүрдэнэ.

Хотгорын чулуун нүүрсний уурхайн усан хангамжийн эх үүсвэрийн дараах судалгаануудыг Ар Пи Эс Акватерра хийсэн байна.

- 2008 оноос Ар Пи Эс Акватерра компани Шинэжинстийн бассейнд анхан шатны газрын доорх усны судалгааг ус шүүрүүлэлт болон уурхайн усны менежментийн хүрээнд хийж эхэлсэн байна.
- 2011 онд төслийн усан хангамж ба уурхайн усны менежментийн үнэлгээг өмнөх нүүрсний хайгуулын ажлаар хийгдсэн өрөмдлөгийн бичиглэл болон урьд өмнө хийгдсэн гидрогеологийн хайгуулын хөтөлбөрүүдэд (Монгол-Оросын судалгаа 1988, Акватерра 2008) тулгуурлан хийсэн. Тус үнэлгээний ажлаар Шинэжинст талбай орчмын 100 км-ийн радиусын хүрээнд Шинэжинстийн бассейны нэлээд хэсгийг хамарсан буюу нүүрсний ордын илүү гүний хэсгүүд болон ойр орчмын аллювийн хурдаснууд зэрэг хэд хэдэн усан хангамжийн эх үүсвэрийн нөөц бололцоо бүхий газруудыг тогтоосон байна.
- 2012 онд өмнөх судалгааны ажлуудын мэдээлэл дээрээ үндэслэн гидрогеологийн хайгуулын иж бүрэн хөтөлбөрийг Шинэжинстийн бассейнд хэрэгжүүлэн, гүний 13, бага болон дунд гүний 9, мониторинг туршилтын 7 цооногуудыг тус тус өрөмдөж тоноглосон. Мөн нэмэлтээр ажилчдын кэмпийн усны хэрэглээг хангах зориулалттай 1 худаг өрөмдөж, тоноглосон. Туршилтын бүх цооногуудад цооногийн үр ашигтай байдал болон уст давхаргын параметрүүдийг тооцох уст давхаргын туршилтуудыг амжилттай гүйцэтгэж, уурхайг ил аргаар ашиглах үед уурхайд орж ирэх усны урсгал болон шүүрэлт, усан хангамжийн нэмэлт эх үүсвэрийг тодорхойлж газрын доорх усны нөөцийг тооцоолсон байна.
- Судалгааны ажлаар ил уурхайд шүүрч орж ирэх усны хэмжээг 50-80 л/с гэж тооцоолсон ба шүүрэлтийн усыг цуглуулж үйлдвэрийн ус хангамжийн хэрэглээнд ашиглана. Шүүрэлтийн усыг уурхайн баруун хойд хэсэгт нийт 8 шүүрүүлэх цооног байгуулж цуглуулах, мөн уурхайн карьерт зумп байгуулан цуглуулахаар тайланд төлөвлөсөн.

Зураг 2. Ус шүүрүүлэх цооногуудын байршил



Хүснэгт 2. Өрөмдөж тоноглосон худгуудын мэдээлэл

№	Худаг дугаар	Цооногийн ашиглалтын усны ундарга, л/сек
1	CSB01	1.7
2	TB01	10
3	TB02	7.5
4	TB03	0.8
5	TB04	1.1
6	TB05	1.
7	TB06	5
8	TB07	9
Нийт		36.6

Барилга байгууламж: Уурхайн барилга байгууламжууд нь баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхон, ил уурхайн засварын газар, тэсэлгээний агуулах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. НУБҮ үйлдвэрийг Шинэжинст сумаас баруун хойш 10.6 км орчим зайд байрлуулахаар төлөвлөсөн бөгөөд 11 га орчим талбайг хамарч байгаа бөгөөд ил уурхайгаас зүүн зүгт ойролцоогоор 6.5 км-ийн зайд байрлана.

Нүүрс баяжуулах үйлдвэр - Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулийн барилга байгууламжийг хоёр жилийн хугацаанд бүтээн байгуулахаар төлөвлөсөн ба 2-р модуль нь төслийн 4 дэх жилээс ашиглалтад орж үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллана. Үйлдвэрийн барилга байгууламжид нүүрс хүлээн авч бутлах хэсэг, агуулах, нүүрс нунтаглах хэсэг, үндсэн баяжуулах хэсэг, компрессорын өрөө, засварын цех, лабораторийн хэсэг, жинлэх хэсэг, эргэлтийн усны насосын байр, харуулын байр, үйлдвэрийн оффис, цайны газар, халуун усны байгууламж, уурын зуухны хэсгүүд багтана.

Зураг 3. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлтийн зураг

Удирдлагын байр, оффис - Удирдлагын байр нь баяжуулах үйлдвэрийн талбайн баруун талд, үйлдвэрийн районы салхины зонхилох чиглэлийн дээд хэсэгт байрлана. Удирдлагын байр нь ажиллагсдын тоо, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байх ба ил уурхайгаас 6км, нүүрс баяжуулах үйлдвэрээс 760м зайд байрлана. Инженер техникийн ажилтын өрөө, цайны газар, захиргааны байр, спорт танхим, уурын зуухны хэсэг, харуулын байр гэсэн байгууламжууд байрлана.

Ажилчдын хотхон - Уурхайн хотхоныг 2 үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөсөн. Төслийн үйлдвэрлэлийн үед ажиллагсдыг 14:14 (14 хоног амарч, 14 хоног ажиллах)-ийн ажил амралтын ээлжтэй байхаар тооцсон бөгөөд тооцоогоор уурхайд хамгийн ихдээ нийт 600 хүн ажиллаж амьдарна.

Зураг 4. Ажилчдын кэмп

Ил уурхайн засварын цех - Ил уурхайн засварын цех нь уурхайгаас хойд зүгт 2.5 км зайд байрлана. Засварын цех өдрийн 2 ээлжээр, ээлжид 12 цагаар ажиллана. Ил уурхайн засварын газарт ашиглалтын жилүүдэд өргөтгөл хийх ба засварын газар нь уурхайн ашиглалтын эхний 3 жилд 792 м^2, 4 дэх жилээс 2,352 м^2 ашигтай талбай бүхий сендвичэн барилга байна.

Зураг 5. Ил уурхайн засварын цех

Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах - Тэсрэх бодисын агуулах байгуулах зориулалттай 5 га талбайн зөвшөөрөл авснаас одоо 2 га талбайд нь агуулахаа байгуулан ашиглаж байгаа бөгөөд цаашид төслийн хүрээнд өргөтгөж ашиглана. Тэсрэх материалын агуулахыг ил уурхайгаас баруун хойд зүгт 2 км зайд аюултай бүсээс гадна байгуулсан.

Зураг 6. Тэсрэх бодисын агуулах

Шатахуун түгээх станц, агуулах – Уурхайн шатах тослох материалын жилийн дундаж хэрэглээ нь дизелийн түлшинд 3,000 тн, дизелийн масло 50 тн, бусад төрлийн шатах тослох материал 7 тн тус тус байна. Шатахуун хадгалах, түгээх станцад 75м^3-ийн багтаамжтай 14 ширхэг бүрэн тоногтой хэвтэй ган сав, 50м^3-ийн багтаамжтай 2 ширхэг усны сав, 5м^3-ийн 1 ширхэг шатахуун хадгалах сав байрлана. Дизелийн масло болон бусад материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төлөвлөж байна.

Зураг 7. Дотоод хэрэгцээний шатахуун хадгалах, түгээх станцын төлөвлөлтийн зураг



Зам тээвэр:

- Ил уурхайн дотоод тээвэр
- Уурхайн гадаргуугийн дотоод тээвэр
- Гадаад тээвэр гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Хатуу хучилттай авто зам – Уурхайн нь өнөөгийн байдлаар төв суурин газруудтай орон нутгийн чанартай шороон замаар холбогддог. Сэкер Ресорсус Монголиа ХХК нь Хотгорын нүүрсний уурхайгаас Нарийнсухайт хүртэл 288.5 км хатуу хучилттай замыг барихаар ЗТБХБЯ-аас (хуучин нэрээр) 2012.01.13-нд зөвшөөрөл авсан. Уг шинээр барих замыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөж замын далангийн ажил хийгдээд байна.

Зураг 8. Хатуу хучилттай авто замын трасс



Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллах үед нийт 1,170 хүний ажлын байр бий болох ба үүнээс ил уурхайд 528 хүн, баяжуулах үйлдвэрт 303 хүн, хотхонд 133 хүн, Улаанбаатар хот дахь төв оффист 25 хүн тус тус шаардлагатай бөгөөд нийт ажиллах хүчний хэрэгцээгээр ил уурхай 45.7 хувь, нүүрс баяжуулах үйлдвэр 23.2 хувь, цахилгаан станц 18.2 хувь, хотхон 11.7 хувь, төв оффис 1.7 хувийг тус тус эзэлж байна.

Ил уурхайн удирдлага ажиллах хүч, зохион байгуулалт – Ил уурхай нь хоногт 12 цагийн 2 ээлжээр ажиллах ба ажилчид 14 хоног ажиллаж, 14 хоног амрах системээр ажиллах бөгөөд хамгийн ихдээ 528 ажилтан ажиллахаар байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах хүч, зохион байгуулалт – Нүүрс баяжуулах үйлдвэрт ажиллах ажилчид нь үйлдвэрийн хүчин чадлын өргөтгөлөөс хамааран 2 үе шаттай нэмэгдэнэ. Баяжуулах үйлдвэрт хамгийн ихдээ 303 ажилтан ажиллана.

Цахилгаан станцын ажиллах хүч, зохион байгуулалт - Цахилгаан станцад нийт 8 хэсэг нэгжийн 107 хүн албан тушаал, ажлын байрны онцлогоос хамаарч хоногт 12 цагийн 2 ээлжээр ажиллах бөгөөд хамгийн ихдээ 205 хүн ажиллана.

Уурхайн хотхоны ажиллах хүч, зохион байгуулалт – Хамгийн ихдээ 133 хүн албан тушаал, ажлын байрны онцлогоос хамаарч хоногт 8 цагийн 2 ээлжээр ажиллана.

Төв оффисын ажиллах хүч, зохион байгуулалт – Эдгээр ажилчид нь уурхайн хүчин чадлаас хамаарахгүйгээр Улаанбаатар хот дахь оффисын 25 байнгын ажилчид байна.

1.6 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтайхил залгадаг ба нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 116 мянган ам километр болно. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны өмнө талын тэгш өндөрлөг, дунд хэсгээрээ Их нуруудын хотгорын төгсгөл тал хээр, өмнөд хэсгээрээ Алтайн цаад говийн цөлөрхөг хээрийн бүсийн хэсэгт хамаардаг.

Баянхонгор аймаг нь хөрс, цаг уурын олон бичил мужид хуваагддаг. Нар салхины эрчим хүчний нөөц сайтай ба Умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эрс тэс уур амьсгалтай.

Физик газар зүй

Хотгорын чулуун нүүрсний орд засаг захиргааны хувьд Монгол улсын баруун өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд оршино. Орд нь Говь-Алтайн нурууны дунд хэсэг (Баянцагааны нуруу, Шинэжинст уулын хооронд) оршдог тул ордын үндсэн хэсэг нь уул, толгодорхог, гадаргуутай районд багтах бөгөөд далайн түвшнээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана. Тус уурхайн талбайн хамгийн өндөр цэг нь Саманд уул ба түүний үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 2347 метр юм. Талбайн гадаргуу нь гуу, жалгаар нэлээд хэрчигдэлтэй, тэдгээрийн адгуудад хошуурсан туугдсууд үүсч, өөрийн гэсэн онцлогтой чулуурхаг товгорхог гадаргууг үүсгэсэн байдаг. Орд газар нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг.

Уур амьсгал

Шинэжинст сум нь нутаг дэвсгэрийн мужлалаар говийн бүс, мелиорацийн мужлалаар умард говийн бүсэд, цаг уурын мужлалаар нэн хуурай дулаавтар мужид багтаж байна. Ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Уур амьсгалын тодорхойлолтыг Шинэжинст цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг үндэслэн бичив. Цаг уурын шинэжинст өртөө нь 1972 оны сүүлчээр байгуулагдсан манай улсын цаг уурын

сүлжээний нэг тулгуур цэг бөгөөд хойд өргөргийн 44°03’, зүүн уртрагийн 99°16’, далайн түвшнээс 2219,2 метр өндөрт оршино. Энэ бүс нутаг жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас ховор хэт хуурай. Жилдээ 120-180 мм хур тунадас ордог бөгөөд хамгийн хүйтэн нь 1-р сард -30-35°C, харин зундаа 7 сард +25+30°C байдаг. Жилийн дундаж температур 0-(+1)°C-т хэлбэлзэх ба салхины чиглэл баруун, баруун урдаас зүүн, зүүн хойшоо байдаг, дундаж хурд нь 2.8-7.3 м/сек-ийн хооронд байна.

Хөрс

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний төрөл, тархац үржил шим тариалангийн бүс, дэд бүс бүрд харилцан адилгүй байдлаар тархсан байдаг. Талбайн баруун талаар ухаа гүвээ толгодын маш нимгэн ялзмагт үеийн давхаргатай, карбонатлаг, цөлөрхөг хээрийн бор хөрс, дунд хэсгээрээ тал газрын ба уулсын хоорондох маш нимгэн ялзмагт үе давхаргатай, зузаан шороон үетэй. Талбайн баруун урд талдаа намхан уул, толгодтой бусад хэсэгтэй гүвээлэг болон тэгш, гадаргадаа жижиг үйрмэг чулуутай (10-15%). Өнгөн хөрс нь салхины элэгдэлд бага зэрэг орсон. Хөрсний ялзмагт үеийн зузаан 12 см, шороон үеийн зузаан нь 1.0-1.7 байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн нийт талбайд элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уур амьсгалын нөлөөгөөр говийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш нимгэн байдаг.

Ургамал

Уурхайн талбайд ургамлын нөмрөгийн хувьд уулыг хээрийн Таана-заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат, таана-үетэн-заримдаг сөөгөнцөрт гэсэн 2 төрлийн хэв шинжүүд бүлгэмдлүүд 15-25% бүрхэц үүсгэн 0.85-1.06ц/га ургацтай ургаж байна. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамааралд ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ. Голлон таана баглуур ургах ба хялгана, агь, тэсэг сийрэг бөгөөд тачир тархалттай байна.

Амьтны аймаг

Шинэжинст сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтын олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархцын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтдаар нэлээд баялаг, уул, аса, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавж болон жижиг шавжнаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

1.7 Төсөл хэрэгжүүлж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Баянхонгор аймаг нь урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Говь- Алтай, баруун хойд хэсгээр Завхан, хойд талаараа Архангай, зүүн, зүүн хойд талаараа Өвөрхангай, зүүн урд хэсгээрээ Өмнөговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Баянхонгор хот нь Улаанбаатар хотоос 630 км зайтай.

Хүн ам: Аймгийн суурин хүн амын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 89643 үүнээс 45453 /50,7%/ эмэгтэй, 44190 /49,3%/ эрэгтэй Баянхонгор аймагт амьдарч байна. Нийт хүн амын 32665 нь аймгийн төвд, 10017 нь сумын төвд, 46961 хүн нь хөдөө амьдарч байна. Өрхийн тоо 26737 болж эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх нь 19432 / 72,7%/, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй 7305 / 27,3%/ өрх байна. Нийт өрхийн 9746 нь аймгийн төвд, 3057 нь сумын төвд, 13934 өрх нь хөдөө амьдарч байна. Баянхонгор аймгийн дундаж наслалт 2020 онд 70.9 байсан бол 2022 онд 71.7 болж 0.8 жилээр нэмэгдсэн байна. Эрэгтэй дундаж наслалт 2022 онд 68.4, эмэгтэй дундаж наслалт 73.7 байгаа нь эмэгтэйчүүд 5.3 жилээр илүү урт насалж байгааг харуулж байна.

Боловсрол: Баянхонгор аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын мэдээгээр 2022, 2023 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 32 сургуульд 19410 суралцагч, сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллагад 6824 хүүхэд сурч хүмүүжнэ.

Сургуулийн бүлэг дүүргэлт 28, цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 32 байгаа бол цэцэрлэгийн хамран сургалт 87, сургуулийн хамран сургалт 98 хувьд хүрчээ. ЕБС-д 973 багш ажиллаж байгаа нь багшийн хангалт 99 хувь, СӨБС 210 багштай үйл ажиллагаа явуулж байгаа нь багшийн хангалт 98 хувьтай байна.

Эрүүл мэнд: 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд 1503 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 214 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 94.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 5.1 хувь нь төржээ. Нялхсын эндэгдэл 2022 оны байдлаар 16 гарчээ. Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт 8128 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 913.3 байгааг өнгөрсөн оны мөн үетэй (2043.6) харьцуулахад 2.6 дахин буурч, коронавирусийн халдварын шалтгаант 2 нас баралт бүртгэгдсэн байна. Нийт 14182 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 22.6 хувийг алсын, 7.4 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо өсөж, нийт дуудлагад эзлэх осол гэмтлийн дуудлага буурсан байна.

БҮЛЭГ 2.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2025 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

2.1 Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Хотгорын нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын дагуу байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзлээ. Агаар цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр кемп орчим
- Амьтан
- Ургамал

2.1.1 Хөрс

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Шатахуун түгээх станц, авто засварын төв зэрэг нь хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй тул талбайг цементлэх шаардлагатай.

Хөрс бохирдолт

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон

- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

2.1.2 Ус

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорх усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй байгаль хаясан тохиолдолд усан орчин бохирдох
- Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй байгаль хаясан тохиолдолд усан орчин бохирдох

Нөлөөлөлд өртөх объект

- Хүн
- Амьтан
- Ургамал

2.1.3 Биологийн олон янз байдал, ургамал, амьтан бусад

- Төсөл хэрэгжих хугацаанд уурхайн олборлолт, барилга байгууламж, хөрсний овоолгууд зэргээс нийт 1,626.7 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устах, нөлөөлөлд өртөх
- Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох.
- Ашиглах химийн бодисуудын ачиж, тээвэрлэх явцад сав баглаа боодол гэмтэх, хадгалалт, ашиглалтын стандарт, хэвийн үйл ажиллагаа алдагдсанаар үүсэх асгаралтын улмаас ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх
- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.

БҮЛЭГ 3.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БҮЛЭГ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчны нөлөөлллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний тодотголийн тайланд тусгагдсан зөвлөмж, заавар, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээээг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна.

БОННҮ тогтоогдсон Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь төслийн хэрэгжилтийн явцад гарч болох сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлж, бууруулах, хяналт тавих, урьдчилан сэргийлэх зорилготойгоор нийт 46 арга хэмжээг төлөвлөсөн. Байгаль орчны болон ХАБЭА инженерийн баг хамтран хяналт тавьж, төлөвлөгөөнд тусгасан нийт 46 арга хэмжээнээс 39-ыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, 7-ыг хэсэгчлэн болон ажлын төлөвлөгөөтэй уялдуулан ирэх онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хүснэгт 4. Биелэлтийн хувь

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлтийн хувь
1	Барилгын ажлын газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Барилгын ажлын үед тоосжилт үүсэх газар шорооны ажлын үед усалгаа хийх	100%
2		Барилгын ажилд ашиглах элс, хайрга, цемент гэх мэт материалыг битүү орчинд хадгалах эсвэл хучиж тоосжилт үүсэхээс сэргийлэх	100%
3	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаа агаарт тоосжилт үүсэх	Уурхайн олборлолтын үед зохиомол мананжуулагч, бодис ашиглан усалгаа хийх	20%
4	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	100%
5		Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлагын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах ба бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.	100%
6		Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	100%
7		Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах	100%
8		Уурхайн дотоод тээврийн замд бороожуулагч болон бодис ашиглан усалгааг хийх	20%
9	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж байх, утаа их ялгаруулдаг болон ашиглалтын	100%

		хугацаа хэтэрсэн агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх машин, техникийг ашиглахгүй байх	
10	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоосжилт	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоос баригчийн хэвийн ажиллагааг хангаж, үйлдвэрлэгчийн заасан хугацаанд засвар үйлчилгээг хийх	20%
11	Нүүрсний агаартай харьцах, хүчилтөрөгчтэй удаан хугацаанд исэлдэх, дулаан хуримтлагдсаны дүнд өөрөө шатах	Агаарын найрлага дахь CO, CO_2, CH_4, хүчилтөрөгчийн түвшинг тогтмол хэмжих. CO ихсэх нь өөрөө шаталтын анхны шинж тэмдэг гарч буй эсэхийг хянахын тулд овоолго, агуулахад термометр, дулааны мэдрэгч суурилуулж хяналт тавих.	80%
12	Төслийн үйл ажиллагаагаар 3,738.7 мян.м3 шимт хөрс хуулна.	Олборлолт болон бусад үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	100%
13		Шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгалах ба удаан хадгалсан хөрс сийрэгжих тул хөрсний овоолгуудын дээд болон хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарьж, шимт хөрсийг салхинд хийсэн, усанд урсах, бохирдох зэргээс хамгаалах	100%
14		Хөрсний овоолгуудын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээг хийх	100%
15		Хөрсний овоолгуудын талбайн хэмжээ, байршил зэргийг тусган бүртгэл хөтлөх.	100%
16		Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх	100%
17	Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн үед шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулах	100%
18		Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг уурхайн бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	100%
19		Шатахуун түгээх станц, агуулахыг байнгын хяналтад байлгаж, гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварлах ба хяналтын бүртгэл хөтөлж, тогтмол үзлэг хийх.	100%
20	Химийн бодисын асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Химийн бодис материалыг холбогдох журам болон хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэлт, хадгалалтын нөхцөлийг нарийн баримтлан ажиллах	100%
21	Хог хаягдлыг стандарт шаардлага хангаагүй нөхцөлд хадгалсан тохиолдолд ойр орчмын хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Зориулалтын бус талбайд хог хаягдал хаяж хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, хог хаягдлын дотоод журмыг боловсруулан ажиллах. Энгийн ба аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хадгалан, хог хаягдлыг тогтмол эрх бүхий байгууллагаар ачиж тээвэрлүүлэх.	100%

22	Төслийн үйл ажиллагааны хүрээнд 79.55 л/с ус ашиглана.	Уурхайн талбайн бүс нутагт газрын доорх усны хайгуул, судалгааны ажлыг усны эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах.	100%
23		Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан, ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллах.	100%
24		Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан ашиглах хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх тухай үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим боловсруулж даган мөрдөж ажиллах.	100%
25		Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах бөгөөд шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	100%
26		Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн ус ашиглалт, хаягдал ус хаях зайлуулахтай холбоотой мэдээллийг усны нэгдсэн мэдээллийн системд бүртгүүлэх	100%
27	Химийн бодисууд, ШТМ зэрэг хор аюул бүхий бодис материалууд осол эрсдэл, хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас асгарсан тохиолдолд усан орчныг бохирдуулах	Аадар бороо, шар усны үерийн ус зайлуулах суваг, шуудуу, далангийн технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх, үерийн усаар бохирдол зөөгдөхөөс сэргийлэх.	100%
28		Төслийн талбайн хэмжээнд байрлах уст цэгүүд, цооногуудаас дээж авч тогтмол хяналт шинжилгээ хийлгэх, хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж бууруулах арга хэмжээг авах	100%
29	Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй үед усан орчин бохирдох	Хаягдал ус цэвэрлэх байгууламжаас байгуулж, хаягдал бохир усны найрлагыг MNS4943:2015 стандартад заасан шаардлагад нийцүүлж цэвэрлэх, саарал усыг дахин ашиглах	100%
30		Хаягдал дамжуулах хоолой, ажилчдын бохир ус цэвэрлэх байгууламж, химийн бодисын агуулахын бүрэн бүтэн байдлыг хянах, хуваарийн дагуу үзлэг шалгалт хийх	100%
31		Хаягдал усны тоо хэмжээ, найрлагад хяналт тавьж, шинжилгээ хийлгэх	100%
32	Төслийн үйл ажиллагаагаар 1,626.7 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устах	Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд аль болох тухайн нутгийн ургамлын үрүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлийг дахин сэргээх арга хэмжээ авах.	100%
33		Уурхайн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх.	100%
	Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга	

34	физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох	сануулга өгөх, МУ-ын улаан ном, Бүс нутгийн болон олон улсын улаан дансанд бүртгэлтэй, олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан ховор, нэн ховор ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүд болон нутгийн иргэдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сурталчилгаа хийж байх.	100%
35		Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллаж, төслийн хугацаанд аймгийн урт хугацааны төлөвлөлттэй уялдуулах.	100%
36	Уурхайлалд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ авах	100%
37		Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх.	100%
38		Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийн ойролцоо анхааруулсан тэмдгүүд байрлуулах	100%
39		Төслийн талбай болон түүний ойр орчимд зэрлэг амьтдын зүйл, нягтшилыг үнэлэх зорилгоор автомат камер суурилуулах, зэрлэг амьтны тархац, нөөцийг үнэлэх зорилгоор шугаман замналын судалгаа хийх, шувуудын судалгаа, махчин шувуудын үүрний байршлыг тогтоох зэргээр хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх	20%
40	Дотоод болон гадаад тээврийн зам нь зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, хуваагдал үүсгэх	Уурхайн ажилчдад тогтоосон зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргэхгүй байх талаар сануулга өгөх, ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтанд мэдээлж, сургалт, сурталчилгаа хийх, уурхайн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд хариуцах албанд хэрхэн мэдэгдэх журамтай байх	100%

БҮЛЭГ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт	Зураг, тайлбар
1	2	3	4	5
Агаар орчин				
1	Барилгын ажлын газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Барилгын ажлын үед тоосжилт үүсэх газар шорооны ажлын үед усалгаа хийх	Төслийн талбайд усалгаанд WT30, WT40 парк дугаартай машинууд өдөрт 12 рейсийн бүтээлтэй уурхайн дотоод зам, технолгийн зам, отвол, кемп нүүрсний склад, зам талбай, ул талбайг зэргийн өдөр бүр 3 машин тогтмол усалгаа хийж байна.	*Усалгаа , усалгааны бүртгэл* 
		Барилгын ажилд ашиглах элс, хайрга, цемент гэх мэт	Барилгын материалыг битүү орчинд хадгалж, шаардлагатай тохиолдолд хучиж тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар	

2		материалыг битүү орчинд хадгалах эсвэл хучиж тоосжилт үүсэхээс сэргийлэх	төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар төслийн талбай дээр барилгын материал их хэмжээгээр буугаагүй байна. Үлдэгдэл барилгын материалыг хучиж тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлээд байна.	*Бараа материал түр хадгалах байр, барилганы материалыг хучсан байдал*
3	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаа агаарт тоосжилт үүсэх	Уурхайн олборлолтын үед зохиомол мананжуулагч, бодис ашиглан усалгаа хийх	Уурхайн олборлолтын үед дотоод замд зохиомол мананжуулагч, бодис ашиглах талаар судлаж үнийг судалгааг авч ажиллаж байна. 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	F13S урвалжийг ашиглахаас өмнө F13S урвалжийг ашигласны дараа *Тоос дарах бодисын судалгаа*

4	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг батлуулж төлөвлөсөн маршрутын замаар тээвэрлэлт хийгдэж байна. Мөн бүх тээврийн хэрэгслийн оператор, ажилчдад анхааруулж сургалт орсон.	 *Уурхайн батлагдсан дотоод маршрут*

5	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлагын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах ба бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS4597:2014 дээрх Монгол улсын стандартын дагуу Авто замын тэмдэг тэмдэглэгээг байршуулж, хөдөлгөөний аюулгүй байдал, тэмдгийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна.	*Тэмдэг тэмдэглэгээ байршуулж буй*
6		Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30 км/цаг, хоосон үед 35-40 км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хурд хэмжих Bushnell багаж ашиглан өдөр бүр тогтмол хяналт хийж ажиллаж байна. Зөрчил 3 удаа гаргасан жолоочид уурхайд тээврийн хэрэгсэл эрхийг хасах, ноцтой зөрчил гаргасан бол төслийн талбайд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах арга хэмжээ авч ажиллаж байна.	СЭКЕРРЕСОРСУС МОНГОЛИА ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ Баталсан огноо: Ерөнхий захирлын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/58 тоот тушаалын 3.3-р Хавсралт Утга | Албан тушаал | Овог нэр | Гарын үсэг Баталсан | Гүйцэтгэх захирал | Жозеф Кейт Борковски Хянасан | Уурхайн дарга | Б.Баасандорж Хянасан | Уурхайн дарга | Д.Аажаргал Боловсруулсан | ХАБЭА, БОнны хэлтсийн ерөнхий менежер | Э.Батцэрэн Улаанбаатар хот 2024 СРМ-КЭ-ЖӨЗ-Х01 Хуудас 1 / 18 *Замын хөдөлгөөний журам, хурдны хэмжилт хийж буй*

7		Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах	Хотгор чулуун нүүрсний ордын 2025 оны 4 дүгээр улирлын зам арчилгаа усалгааны хуваарь гарган уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу гэрээт компаниуд зам арчилгаа болон усалгааг тогтмол хийж байна.	 *Замын засвар арчилгааны хуваарь*
8		Уурхайн дотоод тээврийн замд бороожуулагч болон бодис ашиглан усалгааг хийх	Төслийн талбайд усалгаанд WT30, WT40 парк дугаартай машинууд өдөрт 12 рейсийн бүтээлтэй уурхайн дотоод зам, технолгийн зам, отвол, кемп нүүрсний склад, зам талбай, ул талбайг зэргийн өдөр бүр 3 машин тогтмол усалгаа хийж байна.	   *Усалгаа, усалгааны бүртгэл*

9	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж байх, утаа их ялгаруулдаг болон ашиглалтын хугацаа хэтэрсэн агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх машин, техникийг ашиглахгүй байх	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд төслийн талбайд ашиглагдаж буй 36 техник, тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулан, өдөр тутамд техникийн үзлэгийн хуудсаар хяналт хийж ажиллаж байна.	 *Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, агаар бохирдуулагчийн төлбөр төлсөн байдал*
10	Дизель генераторын түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Дизель генераторааас ялгарах хорт хийг шүүх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг заасан хугацаанд тогтмол солих	Уурхайн хэмжээнд нийт 3 дизель генератор ажиллаж түүний сервис үйлчилгээг 600 мото цаг буюу 25 хоногт 1 удаа хийж техникийн үзлэг, үйлчилгээний тэмдэглэлийг хөтөлж байна. Дизель генераторааас ялгарах хорт хийг шүүх шүүлтүүрийг тогтмол сольж байна.	

11	Усан халаалтын уурын зуухнаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Усан халаалтын уурын зуухнаас ялгарах хорт хийг шүүх хүхэргүйжүүлэх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг заасан хугацаанд тогтмол солих	Одоогоор усан халаалтын уурын зуух буюу цахилгаан станцын ажил бүрэн хийгдээгүй байгаа тул ирэх оны БОМТ төлөвлөгөөнд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	
12	Шатахууны ууршилтаас NMVOC буюу метан биш дэгдэмхий органик бохирдуулагч бодис ялгарч болзошгүй	ШТМ-ын агуулахын орчимд анхааруулах болон таниулах тэмдгийг байршуулах, агуулахын ажилчид шатахуун түгээх станцад хуваарь гарган үзлэг хийх, дутагдал илэрсэн тохиолдолд засах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ШТМ-ын агуулахын орчимд ХАБЭАБО хэлтсийн ажилчид шатахуун түгээх станцад хуваарь гарган үзлэг хийж, дутагдал илэрсэн тохиолдолд залруулах арга хэмжээг авч ажиллаж байна.	 ЭРХЭТ ТҮНШ АЖЛЫН БАЙРНЫ ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН "СЭКЕР РЕСУРСОС МОНГОЛИА" ХХК-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН ҮЗЛЭГИЙН ЗОРИЛГО[1]: Зорилго: Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны хэлтсүүс Хотгорын нүүрсний уурхайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, байгаль орчны тухай багц хууль болон эдгээр хуулийг дагах гарсан дүрэм, журам, стандарт, аюулгүй ажиллагааны горимуудын хэрэгжилтийг хянуулах, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах, засаж залруулах арга хэмжээ авах. ҮЗЛЭГ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСТИЙН БҮРЭЛДЭХҮҮН: Багийн ахлагч: Овог Нэр: Э.Амарсанаа; Албан тушаал: ЭРХЭТ ТҮНШ ХХК-ийн ХАБЭА-н мэргэжилтэн; Гарын үсэг: Багийн гишүүд: Б.Батцэрэн, ЭРХЭТ ТҮНШ ХХК-ийн БО-н мэргэжилтэн; Э.Шинэхүү, ЭН АР ЖИ ХХК-ийн ХАБЭА-н мэргэжилтэн; Г.Ариунболд, ИХ ЛОГИЙН ГОВЬ ХХК-ийн ХАБЭА-н мэргэжилтэн; С.Гансүх, ХОНГОР АЛТАЙН ТАЛ ХХК-ийн ХАБЭА-н мэргэжилтэн ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН ХЭСЭГ, НЭГЖ, АЖЛЫН БАЙР, ОГНОО: Хэлтэс нэгж, компани; Түүний удирдах ажилтан, менежерийн нэр; Огноо: *Шатах тослох материал асгаралтын эсрэг арга хэмжээ, таних тэмдэг, үзлэгийн тайлан*

13	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоосжилт	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоос баригчийн хэвийн ажиллагааг хангаж, үйлдвэрлэгчийн заасан хугацаанд засвар үйлчилгээг хийх	Нүүрс баяжуулах үйлдвэр суурийн ажил эхэлсэн. 2026 онд хэрэгжүүлнэ.	
14	Нүүрсний агаартай харьцах, хүчилтөрөгчтэй удаан хугацаанд исэлдэх, дулаан хуримтлагдсаны дүнд өөрөө шатах	Агаарын найрлага дахь CO, CO_2, CH_4, хүчилтөрөгчийн түвшинг тогтмол хэмжих. CO ихсэх нь өөрөө шаталтын анхны шинж тэмдэг гарч буй эсэхийг хянахын тулд овоолго, агуулахад термометр, дулааны мэдрэгч суурилуулж хяналт тавих.	Нүүрсний овоолго термометр болон дулаан мэдрэгч байршуулсан бөгөөд хяналтыг зөөврийн багаж ашиглан өөрчлөлт гарсан тухай бүрт уулын мастерт мэдэгдэн арга хэмжээ авч ажиллаж байна.	 *Агаарын найрлага дахь CO2 хэмжилтийг зөөврийн багажаар хэмжиж гарсан үр дүнг бүртгэн ажиллаж байна.*

Хөрсөн бүрхэвч, газрын гадарга				
15		Олборлолт болон бусад үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Шимт хөрсийг тухайн ордыг ашиглах ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх БОНХҮ-ийн тайланд тусгаснаар тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгаж, бусад газар шорооны ажлын үед холбогдох төсөл баримт бичигт зааснаар хуулж тарааж, шууж, шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан талбайд 5 м-ийн өндөртэйгөөр хадгалж байна.	 *Шимт хөрс хуулах зөвшөөрөл, ажлын зураг*
